



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.02.25 № 235
танай _____-ны № _____-т

ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ С.ТӨМӨРДУЛАМ
ТАНАА

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын
хяналт, зохицуулалтын газрын 2020 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж
байна.

Хавсралт: 22 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  М.ЭРДЭНЭЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.02.25 № 236

танай _____-ны № _____-т

ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
С.ТӨМӨРДУЛАМ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 дэд зорилтын бүхий 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  М.ЭРДЭНЭЖАРГАЛ

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: /НТАГ-2021/125/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер:

З.Мөнхбаяр Утас: 327734 Цахим хаяг:

munkhbayarz@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр

Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Аудитор: Н.Баттогоо

Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---------------|--|
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НЗД | Нийслэлийн засаг дарга |
| НЗДТГ | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХСОАБХЗГ | Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| АТБӨЯХ | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |

Агуулга

| | |
|--|----|
| 1. Төрийн аудитын санал, дүгнэлт..... | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 7 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 9 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 9 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан..... | 10 |
| 3.Аудитын тайлан | 11 |
| 3.1. Ерөнхий зүйл..... | 11 |
| 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй | 11 |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт | 11 |
| 3.4. Материаллаг байдал | 12 |
| 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд..... | 12 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт | 13 |
| 3.7. Шилэн дансны мэдээлэл..... | 14 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 14 |
| 3.9. Аудитын илрүүлэлт..... | 14 |
| Залруулсан алдаа..... | 14 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил | 15 |
| Аудитын зөвлөмж..... | 15 |
| 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд | 15 |
| 4. Менежментийн захидал | 16 |
| 5.Шалгагдагч байгууллагын хариу..... | 19 |
| 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт..... | 20 |

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>7,829,250.00</u> | <u>212,569,655.00</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 11,115,635.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 11,115,635.00 |
| 3121 | Төгрөг | - | 11,115,635.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | - | 11,115,635.00 |
| 33 | АВЛАГА | 535,570.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 535,570.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 7,293,680.00 | 201,454,020.00 |
| 351 | Түүхий эд материал | - | 159,248,500.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 159,248,500.00 |
| 354 | Хангамжийн материал | 7,293,680.00 | 42,205,520.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 191,000.00 | 14,241,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,808,460.00 | 10,391,100.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 290,000.00 | 3,260,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,004,220.00 | 14,313,120.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>102,764,371.33</u> | <u>899,315,275.62</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 102,764,371.33 | 899,315,275.62 |
| 392 | Биет хөрөнгө | 98,612,704.65 | 334,726,108.22 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | - | 179,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | (10,338,541.63) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 60,199,300.00 | 152,228,332.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,245,452.87) | (29,345,364.29) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 39,957,100.00 | 52,400,148.34 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (298,242.48) | (10,018,466.20) |
| 393 | Биет бус хөрөнгө | 4,151,666.68 | 564,589,167.40 |
| 39301 | Програм хангамж | 1,430,000.00 | 1,430,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (238,333.32) | (714,999.96) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,960,000.00 | 564,860,834.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | (986,666.64) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>110,593,621.33</u> | <u>1,111,884,930.62</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>503,516.00</u> | <u>11,115,635.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 503,516.00 | 11,115,635.00 |
| 413 | Өглөг | 503,516.00 | 11,115,635.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 503,516.00 | - |
| 4136 | Бусад өглөг | - | 11,115,635.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 11,115,635.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>110,090,105.33</u> | <u>1,100,769,295.62</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 110,090,105.33 | 1,100,769,295.62 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 110,090,105.33 | 1,100,769,295.62 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | - | 110,058,051.33 |

| | | | |
|----------|--|------------------------------|--------------------------------|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 110,090,105.33 | 990,711,244.29 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>110,593,621.33</u> | <u>1,111,884,930.62</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 481,570,000.00 | 2,026,398,334.34 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 396,000.00 | 70,531,534.34 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 396,000.00 | 70,531,534.34 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 70,531,534.34 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 70,531,534.34 |
| 120009 | Бусад орлого | 396,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 481,174,000.00 | 1,955,866,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 33,888,000.00 | 15,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,888,000.00 | 15,000,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 447,286,000.00 | 1,940,866,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 447,286,000.00 | 1,940,866,800.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 371,479,894.67 | 1,035,687,090.05 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 371,479,894.67 | 1,035,687,090.05 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 205,452,513.27 | 875,526,180.54 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 134,992,669.00 | 474,182,988.00 |
| 210101 | Үндсэн цалин | 112,524,319.00 | 391,468,926.45 |
| 210102 | Нэмэгдэл | 12,307,350.00 | 29,373,458.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,161,000.00 | 16,137,999.55 |
| 210104 | Урамшуулал | - | 37,202,604.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,874,084.00 | 59,484,109.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,481,210.00 | 40,676,644.12 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,234,933.00 | 4,784,316.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 935,262.00 | 3,800,569.33 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 169,175.00 | 868,029.56 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,053,504.00 | 9,354,550.06 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,147,231.60 | 35,021,416.85 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,790,622.00 | 9,591,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,363,163.00 | 9,216,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,199,056.60 | 5,931,216.85 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 9,900,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 794,390.00 | 382,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,500.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500.00 | - |

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 35,244,000.00 | 274,850,597.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,244,000.00 | 274,850,597.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,192,028.67 | 31,987,069.05 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,210,000.00 | 225,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,200,000.00 | 800,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,782,028.67 | 30,962,069.05 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 166,027,381.40 | 160,160,909.51 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,924,270.00 | 4,842,905.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,924,270.00 | 4,842,905.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 161,103,111.40 | 155,318,004.51 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 161,103,111.40 | 155,318,004.51 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 110,090,105.33 | 990,711,244.29 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 110,090,105.33 | 990,711,244.29 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 481,570,000.00 | 1,966,982,435.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 396,000.00 | 11,115,635.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 396,000.00 | 11,115,635.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 11,115,635.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 11,115,635.00 |
| 120009 | Бусад орлого | 396,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 481,174,000.00 | 1,955,866,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 33,888,000.00 | 15,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,888,000.00 | 15,000,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 447,286,000.00 | 1,940,866,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 447,286,000.00 | 1,940,866,800.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 377,023,600.00 | 1,198,885,361.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 377,023,600.00 | 1,198,885,361.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 210,996,218.60 | 1,038,724,451.49 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 135,204,880.00 | 474,170,656.00 |
| 210101 | Үндсэн цалин | 135,204,880.00 | 391,374,356.45 |
| 210102 | Нэмэгдэл | - | 29,468,028.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 16,125,667.55 |
| 210104 | Урамшуулал | - | 37,202,604.00 |

| | | | |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,693,927.00 | 59,496,441.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,701,937.00 | 42,996,916.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 247,998.00 | 3,926,392.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 198,398.00 | 3,404,959.33 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 49,599.00 | 833,480.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 495,995.00 | 8,334,693.06 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,240,251.60 | 19,280,456.85 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,855,600.00 | 5,555,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,653,163.00 | 7,066,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,731,578.60 | 5,926,856.85 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 999,910.00 | 732,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,587,700.00 | 4,398,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,369,800.00 | - |
| 210602 | Тавилга | 1,217,900.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 4,398,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,387,500.00 | 479,678,897.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 37,387,500.00 | 479,678,897.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,881,960.00 | 1,700,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,681,960.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,200,000.00 | 1,700,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 166,027,381.40 | 160,160,909.51 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,924,270.00 | 4,842,905.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,924,270.00 | 4,842,905.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 161,103,111.40 | 155,318,004.51 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 161,103,111.40 | 155,318,004.51 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 104,546,400.00 | 768,097,074.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 104,546,400.00 | 756,981,439.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 104,546,400.00 | 756,981,439.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 104,546,400.00 | 756,981,439.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 104,546,400.00 | 756,981,439.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (104,546,400.00) | (756,981,439.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | 11,115,635.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 11,115,635.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------------|--|
| C01 | 2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 110,090,105.33 | 110,090,105.33 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 110,090,105.33 | 110,090,105.33 |
| D01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 110,090,105.33 | 110,090,105.33 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -32,054.00 | -32,054.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 110,058,051.33 | 110,058,051.33 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 990,711,244.29 | 990,711,244.29 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 1,100,769,295.62 | 1,100,769,295.62 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-----------------------|--|-----------------------|------------------|----------------|-------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,435,949,400.00 | 1,785,548,795.49 | 650,400,604.51 | 73.30 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,435,949,400.00 | 1,785,548,795.49 | 650,400,604.51 | 73.30 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,430,949,400.00 | 1,780,705,890.49 | 650,243,509.51 | 73.25 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 794,923,200.00 | 474,170,656.00 | 320,752,544.00 | 59.65 |
| 210101 | Үндсэн цалин | 562,849,200.00 | 391,374,356.45 | 171,474,843.55 | 69.53 |
| 210102 | Нэмэгдэл | 84,427,400.00 | 29,468,028.00 | 54,959,372.00 | 34.90 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 72,600,000.00 | 16,125,667.55 | 56,474,332.45 | 22.21 |
| 210104 | Урамшуулал | 75,046,600.00 | 37,202,604.00 | 37,843,996.00 | 49.57 |

| | | | | | |
|-------------|--|------------------|------------------|----------------|--------|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | | 47,818,158.36 | 55.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 107,314,600.00 | 59,496,441.64 | 32,520,783.40 | 56.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,949,200.00 | 3,926,392.57 | 4,022,807.43 | 49.39 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,359,400.00 | 3,404,959.33 | 2,954,440.67 | 53.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,589,800.00 | 833,480.08 | 756,319.92 | 52.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,898,500.00 | 8,334,693.06 | 7,563,806.94 | 52.42 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,621,600.00 | 19,280,456.85 | 1,341,143.15 | 93.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,555,200.00 | 5,555,200.00 | - | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,066,400.00 | 7,066,400.00 | - | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,000,000.00 | 5,926,856.85 | 1,073,143.15 | 84.67 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 732,000.00 | 268,000.00 | 73.20 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,500,000.00 | 4,398,000.00 | 102,000.00 | 97.73 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,500,000.00 | 4,398,000.00 | 102,000.00 | 97.73 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,500,000,000.00 | 1,221,660,336.00 | 278,339,664.00 | 81.44 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,500,000,000.00 | 1,221,660,336.00 | 278,339,664.00 | 81.44 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,590,000.00 | 1,700,000.00 | 1,890,000.00 | 47.35 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,590,000.00 | 1,700,000.00 | 1,890,000.00 | 47.35 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,000,000.00 | 4,842,905.00 | 157,095.00 | 96.86 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,000,000.00 | 4,842,905.00 | 157,095.00 | 96.86 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,000,000.00 | 4,842,905.00 | 157,095.00 | 96.86 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,435,949,400.00 | 1,785,548,795.49 | 650,400,604.51 | 73.30 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,435,949,400.00 | 1,785,548,795.49 | 650,400,604.51 | 73.30 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 2,435,949,400.00 | 1,785,548,795.49 | 650,400,604.51 | 73.30 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 60.00 | 44.00 | 16.00 | 73.33 |
| 620001 | Удирдах ажилтан | 2.00 | 2.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 53.00 | 37.00 | 16.00 | 69.81 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | - | 100.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 15,000,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 15,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 15,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,000,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 15,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,000,000.00 |

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга С.Төмөрдулам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, ашиглалтын норм нормативыг харгалзалгүйгээр хангамжийн материал зарлага болгосон, НБББББ-ийг УСНББОУС-ийн дагуу өөрчлөх, татварын цахим төлбөрийн баримтын системд худалдан авалт бүртгээгүй талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Нийслэл дэх Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Баттогоо хариуцаж хэрэгжүүлэв.

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01-03/26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын үйл ажиллагааны чиг үүргийг *“Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар хотын цаашдын хөгжлийг хангах тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлж, иргэдийн амьдрах орчны ая тух, аюулгүй байдлыг хангасан хот болон хөгжихөд хотын стандартын баримт бичгийг боловсруулж, олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж ажиллах.”* гэж тодорхойлсон.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын нь 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд *бага* гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт *үр нөлөөтэй* байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 371,479.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 7,429.6 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,035,687.1 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 20,713.7 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардал өмнөх оноос 2 дахин өссөнтэй холбоотой юм.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,001,291.3 мянган төгрөгөөр буюу 9 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө бараа материалын данстууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|------------------|--------------------|--------------------|
| | | | 3=2-1 |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 11,115.6 | 11,115.6 |
| Авлага | 535.6 | 0 | (535.6) |
| Урьдчилгаа | 0 | 0 | - |
| Бараа материал | 7,293.7 | 201,454.0 | 194,160.3 |
| Үндсэн хөрөнгө | 102,764.4 | 899,315.3 | 796,550.9 |
| Нийт хөрөнгө | 110,593.6 | 1,111,884.9 | 1,001,291.3 |
| Өглөг | 503.5 | 11,115.6 | 10,612.1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 110,090.1 | 1,100,769.3 | 990,679.2 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 110,593.6 | 1,111,884.9 | 1,001,291.3 |

Мөнгөн хөрөнгө дансны 11,115.6 мянган төгрөгийн үлдэгдэл нь барьцаа хөрөнгийн өглөг үүссэнтэй холбоотой.

Бараа материалын эхний үлдэгдэл 7,293.7 мянган төгрөг байна. Тайлант онд 234,563.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 40,402.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж 201,454.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал нэмэгдсэн шалтгаан нь *Нэг хот-Нэг стандарт* зорилтын хүрээнд хотын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандартуудыг хэвлүүлж бараа материал дансанд бүртгэж авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 899,315.3 мянган төгрөг болж 796,550.9 мянган төгрөгөөр өссөн нь НЗД А/199 тоот захирамжийн дагуу 561,900.8 мянган төгрөгийн хотын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандартууд хийлгэж биет бус хөрөнгөөр бүртгэсэн, 179,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 79,093.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,111,884.9 мянган төгрөг болж 1,001,291.3 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой.

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,544,828.3 мянган төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,474,692.8 мянган төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 2,435,949.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 100.0 хувь баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 19 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,435,949.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,940,866.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,785,548.8 мянган төгрөгийг зарцуулж 155,318.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,785,548.8 мянган төгрөг буюу 73.3 хувьтай байгаа нь батлагдсан орон тоогоор ажиллаагүй улмаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 320,752.5 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл зардлыг 47,818.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 1,073.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 278,339.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар НЗД-ын 2020 оны А/95 тоот захирамжаар Нэг хот-Нэг стандарт зорилтын хүрээнд зөвөлгөөнд шаардлагатай бичиг хэргийн зардалд 15,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 85 мэдээллээс хугацаандаа оруулсан 48 мэдээлэл, 1 хугацаа болоогүй мэдээлэл, 1,798,334.1 мянган төгрөгийн орлогын 11 гүйлгээ, 402,368.6 мянган төгрөгийн зарлагын 25 гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,266.1 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 95 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 706,872.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, аудитын явцад 696,255.4 мянган төгрөгийн алдааг залруулж, шилэн дансны мэдээлэлд албан шаардлага хүргүүлж, 10,616.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай нийт 696,255.4 мянган төгрөгийн залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Хотын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандартуудын хийлгэсэн ажлын хөлсний 518,100.8 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасныг биет бус хөрөнгөөр бүртгүүлсэн.
2. Бараа материалын нэр төрөл тодорхой бус, ангилал 159,248.5 мянган төгрөгөөр буруу бүртгэсэн.
3. Бараа материал дансанд ШТС-аас авсан 3,030.0 мянган төгрөгийн шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгосон талоноор тооцоо бодсон.
4. Худалдан авсан 5,400.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод бүртгэлгүй шууд зардалд тайлагнасан.
5. Аж ахуйн материал дансанд 10,476.1 мянган төгрөгийн хангамжийн материал бүртгэсэн, хөрөнгийн ангилал буруу хөтөлсөн.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд цахим Е баримтын дүнгээс 6,655.7 мянган төгрөгийн зөрүүтэй төлбөр шилжүүлсэн /баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2. "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудыг зөрчсөн.

1.2 Эрсдэл:

- Төсөв үндэслэлгүй төлөвлөгдөх, хяналтгүй зарцуулагдах, худалдан авалт бодитоор хийгдэхгүй байх;
- Хууль тогтоомжууд зөрчигдөж, татварыг нуун дарагдуулах боломжийг бусдад олгох;

1.3 Өгсөн зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2, 17.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэх.
- Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх.
- Цаг тухайд нь цахим Е баримтыг хангуулан бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ашиглалтын норм нормативыг харгалзалгүйгээр 701.0 мянган төгрөгийн хангамжийн материалыг зарлагдсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 2006.11.27-ны өдрийн 388 тоот тушаалын 1 хавсралтын 3 бүлэг "Зардлыг хүлээн зөвшөөрөх ба үнэлэх" хэсгийн 3.2 дахь заалт "... гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

2.2. Эрсдэл:

- Санхүүгийн тайланд бараа материал дутуу илэрхийлэгдэх;
- Хөрөнгө шамшигдах, алга болох;

2.3. Өгсөн зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын 3.2 дахь заалтыг заалтыг хэрэгжүүлэх.
- Бараа материалын ангиллыг зохих журмын дагуу үнэн зөв ангилж бүртгэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

3. Программ хангамжийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

НБББББ-ийг УСНББОУС-ийн өөрчлөлт болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-тай нийцүүлэн шинэчлэн боловсруулаагүй нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.”Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалтыг хэрэгжүүлээгүй.

3.2. Эрсдэл:

- НБББББ-т өөрчлөлт хийгээгүй байх;
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэх.
- УСНББОУС болон нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, заавартай нийцүүлэн НБББББ-ийг шинэчлэн боловсруулах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Шатах тослох материалын 3,260.0 мянган төгрөгийн мөнгөн талон их хэмжээгээр авч үлдсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь “ ... төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.” заалтыг хэрэгжүүлэхгүй.

4.2. Эрсдэл:

- Төсөв үндэслэлгүй төлөвлөгдөх, хяналтгүй зарцуулагдах;

4.3. Өгсөн зөвлөмж:

- Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалтыг хэрэгжүүлэх.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Шалгагдагч байгууллагын хариу



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,
Ц.Жигжиджавын гудамж-7/1, Хангарди ордон, 15160-0011
Утас/Факс: 7011-8040, <http://www.standart.ub.gov.mn>

2021.02.24 № 01/48
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Тус газрын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын үр дүнтэй танилцлаа.

Аудитын үр дүнд гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэн зөрчил дутагдал гаргахгүй байх талаар цаашид анхаарч ажиллах болно.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

1150500040

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | |
|------------------------------|---|--------------------------------------|
| Огноо: 2020.02.16 | Аудитын нэр: Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: НТАГ-2021/40/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|------------|---------------------------------------|---|----------------------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Хотын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандартуудын хийлгэсэн ажлын хөлснийг шууд зардлаар тайлагнасныг биет бус хөрөнгөөр бүртгүүлсэн. | 518,100.8 | Залруулсан | Дарга, нягтлан бодогч | С.Төмөрдулам Б.Түмэнжин |
| 2 | Бараа материалын нэр төрөл тодорхой бус, ангилал буруу бүртгэсэн | 159,248.5 | Залруулсан | Дарга, нягтлан бодогч | С.Төмөрдулам Б.Түмэнжин |
| 3 | Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгосон талоноор тооцоо бодсон | 3,030.0 | Залруулсан | Дарга, нягтлан бодогч | С.Төмөрдулам Б.Түмэнжин |
| 4 | Худалдан авсан бараа материалыг орлогод бүртгэлгүй шууд зардалд тайлагнасан | 5,400.0 | Залруулсан | Дарга, нягтлан бодогч | С.Төмөрдулам Б.Түмэнжин |
| 5 | Аж ахуйн материал дансанд хангамжийн материал бүртгэсэн, хөрөнгийн ангилал буруу хөтөлсөн. | 10,476.1 | Залруулсан | Дарга, нягтлан бодогч | С.Төмөрдулам Б.Түмэнжин |
| 6 | Тайлант хугацаанд цахим Е баримтын дүнгээс зөрүүтэй төлбөр шилжүүлсэн /баримтын бүрдлийг ханган ажиллаагүй. | 6,655.7 | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | С.Төмөрдулам Б.Түмэнжин |
| 7 | Ашиглалтын норм нормативыг харгалзалгүйгээр хангамжийн материалыг зарлагдсан. | 701.0 | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | С.Төмөрдулам Б.Түмэнжин |
| 8 | Тайлант хугацаанд цахим Е баримтын дүнгээс зөрүүтэй төлбөр шилжүүлсэн /баримтын бүрдлийг ханган ажиллаагүй | 3,260.0 | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | С.Төмөрдулам Б.Түмэнжин |
| 3 | НБББББ-ийг УСНББОУС-ийн өөрчлөлт болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн | - | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | С.Төмөрдулам Б.Түмэнжин |

| | | | | | |
|------------|--|------------------|-----------------|-----------------------|----------------------------|
| | дансны заавар"-тай нийцүүлэн шинэчлэн боловсруулаагүй | | | | |
| 4 | Шилэн дансанд 1,798,334.1 мянган төгрөгийн орлогын 11 гүйлгээ, 402,368.6 мянган төгрөгийн зарлагын 25 гүйлгээг мэдээлээгүй | - | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | С.Төмөрдулам Б.Түмэнжин |
| ДҮН | | 706,872.1 | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ

Хянасан:

Аудитын 2 дугаар хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер



З.Мөнхбаяр

Аудитын менежер

Д.Отгонбаяр

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Н.Баттоогоо